



БАТЛАВ
ШУТИС-ийн
РЕКТОР



Т. НАМНАН

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН “28” ДАХЬ УДААГИЙН
2026 ОНЫ БАГШ, АЖИЛЧДЫН СПОРТЫН НААДМЫН УДИРДАМЖ**

Нэг. Тэмцээний зорилго

Боловсролын тухай хууль, Биеийн тамир спортын тухай хуулийг хэрэгжүүлэн багш, ажилчдын дунд биеийн тамир спортыг хөгжүүлэх, спортоор хичээллэх сонирхлыг өрнүүлэх, аварга баг тамирчдыг тодруулах зорилготой.

Хоёр. Тэмцээний төрөл, зохион байгуулах хугацаа

№	Төрлүүд	Хүний тоо			Хугацаа	Хариуцах эзэн	Зохион байгуулах газар
		Эр	Эм	Дас			
1	Шатар	Баг /5 хүнтэй/ Ганцаарчилсан			2026 оны 1-р сарын 15-ны 09 ⁰⁰ цагт	Ч.Навчаа	Номын сан
2	Волейбол	12	12	2	2026 оны 1-р сарын 12-14-нд 09 ⁰⁰ цагаас	М.Бат-Очир Б. Дуламсүрэн	2-р байр спорт заал, Хичээлийн 5-р байр
3	Ширээний теннис	Баг /5 хүнтэй/ Ганцаарчилсан			2026 оны 1-р сарын 15-ны 13 ⁰⁰ цагт	М.Амаржаргал	2-р байр спорт заал
4	Нийтийн гимнастик /2 төрөл/	12 (9+3)		1	2026 оны 1-р сарын 15-ны 10 ⁰⁰ цагт	Г.Ерөөлбат /Мэдээллийг 99995158-с/	2-р байр спорт заал
5	Сагсан бөмбөг	12	12	2	2026 оны 1-р сарын 16-18 9 ⁰⁰ цагаас	Б.Ганзориг	2-р байр спорт заал, Хичээлийн 5-р байр
6	Биллиард	Захирлын зөвлөл			2026 оны 1-р сарын 15-ны 10 ⁰⁰ цагт	Б. Бадам-Очир	Биллиардын клуб
7	Дартс	3		3	2026 оны 1-р сарын 15-ны 10 ⁰⁰ цагт	Л. Пүрэвraagчаа	8-р байр 12 давхар

Гурав. Тэмцээний зохион байгуулалт

ШУТИС-ийн Багшийн хөгжлийн төв, ХШУС-ийн Биеийн тамир, спортын тэнхим хамтран зохион байгуулна. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургуулиуд удирдамжинд заасан төрөл тус бүрт баг, тамирчдаа оролцуулна. Спортын тэмцээний нээлтийн нэгдсэн ажиллагаа 2026 оны 01 дүгээр сарын 13-ны 17⁰⁰ цагаас, хаалтын ажиллагаа сагсан бөмбөгийн тэмцээний сүүлийн өдөр

зохион байгуулагдана. Нээлтийн нэгдсэн ажиллагаанд баг тамирчид сургуулийнхаа туг, хаягаа барин, жигд тоглолтын хувцастай оролцоно.

Дөрөв. Шагнал, урамшуулал, багийн дүнг бодох

Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулж, нийлбэр дүнгээр 1, 2, 3-р байр эзлүүлж, цом, өргөмжлөл, дурсгалын медаль мөнгөн шагналаар шагнаана.

- ☐ Сагсан бөмбөг, волейболын төрөлд эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 тамирчныг шилдэг тоглогчоор шалгаруулна.
- ☐ Нийтийн гимнастикийн тэмцээн 2 төрлөөр заавал хийх дасгалаар зохион байгуулж нийлбэрээр багийн дүнг гаргаж байр эзлүүлэнэ. Үүнд:
 - 9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрөл.
 - 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн төрөл.

Нийтийн гимнастикийн дээрх 2 төрлийн заавал хийх дасгалын удирдамж, холбоосыг цахим шуудангаар болон ШУТИС-ийн веб хуудасны мэдээлэл хэсэгт байршуулна. Нэмэлт мэдээллийг тухайн сургуулийн багийн ахлагч нар зохион байгуулагч багш Г.Ерөөлбат /99995158 дугаар/-аас холбогдож авна уу.

- ☐ Нийт багийн нийлбэр дүнг медалийн тоо, чанараар тооцон, өгсөх системээр дүгнэж байр эзлүүлнэ. Үүнд:
 - Алтан медаль 25 оноо
 - Мөнгөн медаль 15 оноо
 - Хүрэл медаль 10 оноо
 - 4-р байр 5 оноо

Жич: Ганцаарчилсан төрлийн амжилт багийн дүнд хамаарахгүй.

Тав. Оролцох багуудын эрхийн төлбөр

Сургууль тус бүр тэмцээний эрхийн төлбөр төгрөгийг ШУТИС-ийн 1102928177 тоот дансанд тушаана.

Зургаа. Тэмцээн явагдах систем

- Багийн тооноос хамаарч техникийн зөвлөгөөн дээр тэмцээн явуулах системийг тохирно.
- Багууд нэр, дугаар бүхий дүрмийн дагуу тоглолтын өмсгөлтэй байна.
- Багууд 1 тоглолтын өмнө ирсэн байна.

Долоо. Багийн бүрэлдэхүүн

- ☐ Тэмцээний төрлүүдэд бүрэлдэхүүн сургуулиудаас 2025 оны 01 тоот тушаалд нэр орсон үндсэн багш, ажилтан, ажилчин байна. Гэрээт багш, ажилтан тэмцээнд оролцохгүй. Сургуульд хамааралгүй тамирчин тоглуулсан нь тогтоогдвол тоглолтыг хожигдсонд тооцно.
- ☐ Спорт наадмын “Нийтийн гимнастик”-ийн тэмцээний багийн бүрэлдэхүүнд бусад спортын төрлийн (*Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Шатар*) тэмцээнд оролцож байгаа тамирчин оролцохгүй тухайн сургуулийн санхүү, салбар тэнхимийн эрхлэгч, сургалтын алба, үйлчилгээний ажилтан, сургалтын мастер зэрэг 12 хүний бүрэлдэхүүнтэй байна.
(Жич: Зарим Бүрэлдэхүүн сургуулийн онцлог, боловсон хүчний нөөц, орон нутгаас оролцох багийн бүрэлдэхүүнээс хамаарч Сагсан бөмбөг, Волейболын эрэгтэй/ эмэгтэй багаас

нийтдээ хүйс хамаарахгүй 2 хүртэлх тоглогчийг нийтийн гимнастикийн тэмцээнд оролцуулахыг зөвшөөрнө.)

Найм. Техникийн зөвлөгөөн

Техникийн зөвлөгөөний хурал 2026 оны 01 дүгээр сарын 05-ны 15⁰⁰ цагаас **ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн өрөөнд** /1-203/ болно. Техникийн зөвлөгөөнд бүрэлдэхүүн сургуулиудын БХТ-ийн төлөөлөл, багийн ахлагчийн хамт дараах материалыг бүрдүүлэн оролцоно. Үүнд:

1. Багийн баталгаажуулсан мэдүүлэг
2. 2025 оны 01 тоот тушаал захирлын тушаал
3. Нийгмийн даатгалын дэвтэр /Материалуудыг хүний нөөцийн алба шалгаж баталгаажуулна./
4. Эрхийн төлбөр төлсөн баримт

Ес. Мэдүүлгийн заавар /А4 цаасан дээр хөндлөнгөөр бичнэ./

Батлав. ШУТИС-ийнсургуулийн захирал.....

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2026 ОНЫ СПОРТ НААДМЫНТӨРӨЛД ОРОЛЦОХ.....СУРГУУЛИЙН БАГИЙН МЭДҮҮЛЭГ

эр/эм

Зураг	Хувийн дугаар	Овог нэр	Албан тушаал	Регистр	Биеийн өндөр	Биеийн жин	Цол зэрэг	Үүрэг

Багийн ахлагч:...../утас/.....

Багийн дасгалжуулагч:...../утас/.....

Жич: *Тэмцээнд оролцож байгаа бүх сургууль тамирчдаа эрүүл мэндийн даатгалд заавал хамруулсан байх шаардлагатай.*

Тэмцээний ерөнхий шүүгч:

БТСТ-ийн Ахлах багш

Амар

М.Амаржаргал

